



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2014 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/116

Сүхбаатар

**Авлигын эсрэг үйл ажиллагааг
сайжруулах зарим арга хэмжээний тухай**

Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг улсын хэмжээнд үнэлсэн 2013 оны үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан шалтгаан нөхцлийг арилгах, зөрчил дутагдлыг засаж, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, 6,1-ийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газраас 2013 онд гаргасан “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу тухайн жилд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааг иргэд олон нийтийн санал оролцоонд тулгуурлан төлөвлөж, хэрэгжилтийг ханган, явц үр дүнг ил тод мэдээлж ажиллахыг аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бүх шатны байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

2. Байгууллагын, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрхэлж, удирдлага, хамт олныг зөвлөгөө дэмжлэг үйлчилгээгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, баг, ажлын хэсгийг байгууллагын нөхцөл онцлогт зохицуулан байгуулж үр нөлөөтэй ажиллуулахыг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

3. Нутгийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллага, төрийн албан хаагчдын гэрээ, үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам, иргэдээс авах сэтгэл ханамжийн санал асуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих хариуцлага, ёс зүйн асуудлыг тусган хэрэгжилтийг тухай бүр тооцож байхыг нутгийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Төсвийн орлого, зарлага, төсвийн хөрөнгөөр хийх ажил үйлчилгээний шалгаруулалт, гүйцэтгэлийн ил тод байдлыг хангахад гарч байгаа алдааг засах, энэ үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо хяналтыг сайжруулах нөхцөл боломжийг дээшлүүлэх үр нөлөөтэй ажил, арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч, төрийн сангийн төлөөлөгч, аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга нарт даалгасугай.


5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, санаачилга, идэвхийг дээшлүүлэх зорилго бүхий “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй орчны төлөө” зохист сарын нэгдсэн ажиллагааг зөвлөн туслах, соён гэгээрүүлэх чиглэлээр 2014 оны 04 дүгээр сарын 05-наас эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулж дүнг нэгтгэж, мэдээлж тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

6. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдож гарсан өргөдөл санал хүсэлтийн дагуу явуулах ажиллагаа, нутгийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудаас хүний нөөцийн асуудлаар гаргаж байгаа шийдвэр, үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, хариуцлага, харилцаа хандлагыг эрхэмлэх хууль тогтоомж, дүрэм журам, тогтоосон хэм хэмжээний хэрэгжилтийг хангуулахад үйл ажиллагаагаа түлхүү чиглүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд зөвлөсүгэй.

7. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажил, амьдралын ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр, үр нөлөөтэй хяналт зөвлөгөө дэмжлэгээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллахыг аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн бус байгууллагын дарга удирдлага, нийт иргэдэд уриалсугай.

8. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, явц үр дүнг мэдээллийн бүх хэрэгслээр олон нийтэд хүргэж, мэдээлж тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БҮРЭНБАТ